

Улсын аварга шалгаруулах тэмцээнээс медаль авсан баг тамирчид:

2019 оны 01 сарын 04-06-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан сагсан бөмбөгийн U13 насны Улсын аварга шалгаруулах тэмцээнд Говьсүмбэр аймгийн баг тамирчид амжилттай оролцлоо. Тэмцээнд хот, хөдөөгийн 10 багийн тамирчид оролцож өрсөлдснөөс Б.Баттогтох дасгалжуулагч, Б.Нэргүйбаатар туслах дасгалжуулагчтай Говьсүмбэр аймгийн Хөвгүүдийн баг тамирчид хүрэл медаль хүртлээ.



Өсвөрийн үеийн усанд сэлэлтийн улсын аварга шалгаруулах тэмцээн нь 2019 оны 04 сарын 10-13-ны өдрүүдэд Улаабатар хотод зохион байгуулагдлаа. Тэмцээнд 19 клубын 240 гаруй тамирчид хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Тус тэмцээнд Говьсүмбэр аймгаас 15 тамирчин, дасгалжуулагчийн хамт оролцож, тамирчид 12-14 насны зайд уралдсанаас Ж.Баярцог далайн гахай сэлэлтээр 100м, 200м тус тус хүрэл, Б.Баяржавхлан холимог 200м зай уралдс хүрэл, 9-11 насны О.Оргил 200м холимог сэлэлтийн хүрэл медаль, 12-14 насны Б.Жаргалмаа мэлхий 50м зайд 3-р зэрэг болзол хангасан амжилттайгаар тэмцээнийг өндөрлүүлсэн.



2019 оны самбо бөхийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 04 сарын 18-21-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотноо амжилттай зохион байгуулагдаж нийт 26 багийн 854 гаруй тамирчид оролцлоо. Говьсүмбэр аймаг 2 дасгалжуулагч 16 тамирчины хамт оролцож бага насны хөвгүүдийн ангиллийн 24кг жинд Биеийн тамир спортын газрын тамирчин М.Бүүвэйбаатар хүрэл медаль, шагналт 5-р байранд биеийн тамир спортын газрын тамирчин 30 кг жинд Н.Баясгалан, 52кг жинд Х.Ариунзул, 60кг жинд П.Номинчимэг, +50 кг жинд О.Пүрэвбаатар нар амжилттай орлоо.



Төв аймгийн зуунмод хотноо Масрестлингийн 2019 оны улсын аварга шалгаруулах тэмцээн 5 дугаар сарын 8,9-нд зохион байгуулагдлаа. Тухайн тэмцээнд Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэсийн тамирчин, Аймгийн арслан Д.Түмэнжаргал 120 кг жинд хүрэл медаль хүртсэн байна.

Мөн Монголын чөлөөт бөхийн мастеруудын холбооны Улсын аварга шалгаруулах тэмцээн нь 2019 оны 05 сарын 11,12-ны өдрүүдэд Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулагдсан. Тэмцээнд нийт 200 гаруй тамирчид "А", "В", "С", "D", "E" ангиллын 62, 70, 78, 88, 100, 130 кг-ын жинд 120 багц медалийн төлөө өрсөлдлөө.Тэмцээнд Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэсийн тамирчин, Аймгийн арслан Д.Түмэнжаргал В" 41-45 насны ангилалын 130 кг жинд мөнгө медаль хүртсэн амжилт дахин гаргасан байна.



Москва-1980 зуны Олимпийн XXII их наадмын хүрэл медальт, МУГТ Р.Даваадалайгийн нэрэмжит жүдо бөхийн өсвөр үеийн Улсын аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 05 сарын 16-наас 05 сарын 19-ны өдрүүдэд Ховд аймагт амжилттай зохион байгуулагдаж нийт 21 аймаг, 9 дүүрэг, спортын клубын нийт 40 багийн 700 гаруй өсвөрийн тамирчид авхаалж самбаага сорин өрсөлдлөө. Говьсүмбэр аймаг 1 дасгалжуулагч 7 тамирчины хамт оролцож 30кг жинд Шивээговь сумын Шивээ-Овоо ХК-ний хаялга спорт клубын тамирчин М.Эрдэнэбат мөнгө медаль, +50 кг жинд Тамирчин Б.Есүхэй хүрэл медаль, Н.Баясгалан шагналт 5-р байранд шалгарсан амжилт гаргасан.



Улаанбаатар марафон 2019 олон улсын тэмцээнд 30 орны 30000 гаруй оролцсон тэмцээний 35-54 насны 21.095 км -н насны ангилалд 4-р байр эзлэж хүрэл медаль өргөмжлөл, мөн 18 аас дээш насны ангилалын 10км-н зайд П.Төгөлдөр 8-р байр эзлэж хүрэл медаль өргөмжлөл, 21.095 км -н 18-аас дээш насанд Д.Ичинхорлоо амжилттай оролцсон.



Үндэсний шагайн харвааны 2019 оны өсвөрийн Улсын аварга шалгаруулах тэмцээний хувийн цуваа харваа болон багийн төрөлд Говьсүмбэр аймгийн өсвөрийн залуу харваач Д.Зүмбэрэл хос мөнгөн медаль хүртлээ.



“ УШУ САНДА-2019” Улсын аварга шалгаруулах тэмцээнийг 06 сарын 22-23-ны Дархан-уул аймагт амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд Шивээговь сумын Шивээ-Овоо ХК-ний дэргэдэх хаялга спорт клубын тамирчид амжилттай оролцлоо. Өсвөрийн хөвгүүдийн 34кг жинд Ж.Жамъяандорж хүрэл, 36кг жинд Б.Баяр-Эрдэнэ, 48кг жинд Б.Хишигбаяр нар хүрэл медаль, 48кг жинд М.Мөнхжаргал нар мөнгө медаль, залуучуудын насны ангилалд 48 кг жинд М.Мөнхнасан мөнгөн медаль, +80кг жинд Н.Төгөлдөр алтан медаль, охидын 54кг жинд А.Үүрцайх алтан медаль, +60кг жинд Э.Эрдэнэцэцэг алтан медаль, Насанд хүрэгчдийн +75 кг жинд ОУХМ Л.Зоригтбаатар хүрэл медаль хүртсэн. Багийн дүнгээр 3 алтан, 2 мөнгөн, 4 хүрэл хүртэж 2-р байранд шалгарсан.



Хөнгөн атлетикийн спортын мастер Хэт холын зайн гүйлтийн нэрт тамирчин монгол улсын 24 удаагийн аварга Биеийн тамир спортын тэргүүний ажилтан Бэлтгэл ахмад Б.Ванданочирын нэрэмжит “Алтан мастер”-уудын хөнгөн атлетикийн аварга шалгаруулах тэмцээнд Говьсүмбэр аймгаас 3 тамирчин оролцож 1 мөнгө 3 хүрэл медаль хүртлээ.



Монгол Улсын гавьяат дасгалжуулагч Лувсандоржийн ЦЭДЭНСОДНОМ агсны нэрэмжит волейболын СУПЕР - 8 идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээн Чойр хотноо 08 сарын 01-07-ны хооронд зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд 6 аймаг, 1 дүүргийн эмэгтэй 7, эрэгтэй 6, нийт 13 багийн 160 гаруй тамирчид оролцон өрсөлдсөн юм.

Тус тэмцээний Л.Цэдэнсодном агсны гэр бүл, үр хүүхдүүд, үе үеийн шавь нар нь хамтран зохион байгууллаа.

ЭМЭГТЭЙ АНГИЛАЛД:

1-р байр: ОУХМ Ж.Уранчимэг дасгалжуулагчтай, Н.Урангоо ахлагчтай Говь-Алтай аймгийн баг

2-р байр: СдМ Г.Номин дасгалжуулагчтай, Ж.Саруул ахлагчтай Ховд аймгийн баг,

3-р байр: СМ Д.Өлзийхутаг дасгалжуулагчтай, У.Мөнх-Ану ахлагчтай Уурхайчин 21 баг,

ЭРЭГТЭЙ АНГИЛАЛД:

1-р байр: ОУХМ Г.Баярсайхан дасгалжуулагчтай, Б.Төгөлдөр ахлагчтай Уурхайчин 21 баг

2-р байр: ОУХМ Ч.Түмэндэмбэрэл дасгалжуулагчтай, Б.Тамир ахлагчтай Ховд аймгийн баг

3-р байр: СМ Г.Баасанхүү дасгалжуулагчтай, Б.Дөлгөөн ахлагчтай Орхон баг,

ТЭМЦЭЭНИЙ ШИЛДЭГҮҮД:





МХБХ-ны 2019 оны улсын аварга шалгаруулах 21 аймгийн “Үндэсний цом-2019” тэмцээн 2019 оны 08-р сарын 04-13-ны өдрүүдэд Хөвсгөл аймгийн Мөрөн хотод явагдлаа. Тус тэмцээнд манай аймгийн баг тамирчид Б.Буянтогтох, Д.Пүрэвням дасгалжуулагчид 19 тамирчин нийт 21 хүний бүрэлдэхүүнтэй оролцов. Тэмцээний А хэсэгт 5 багтай орж 4 тоглолт хийн нэг ч хожигдолгүйгээр хэсгээсээ 1-ээр шалгаран шигшээ 8-д шалгаран цаашид 2 тоглолт хийн шагналт 4-р байрт шалгарсан байна. Манай аймгийн тамирчин Э.Энхмөнх тэмцээний явцад 9 гоол хийн тус тэмцээний “Мэргэн бууч”-аар шалгарсан юм.



Монголын мастеруудын спортын 5-р наадамд Говьсүмбэрчүүдээ төлөөлж 28 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, шатрын төрөлд Ч.Рэнцэнмядаг мөнгөн медаль, хөнгөн атликийн төрөлд Д.Ариунжаргал хүрэл медаль, теннисний төрөлд Л.Энхмөнх 4-р байр, хөнгөн атлетикт Р.Цэндмаа 5-р байр, мөн шатрын төрөлд Г.Бямбаа, Д.Гонгор, Э.Хангал, Г.Дэлгэрсуурь, хөнгөн атлетикт Д.Чулуунцэцэг, Л.Энхмөнх, дартсын тэмцээнд Ч.Рэнцэнмядаг, О.Амарбаяр, Д.Ариунжаргал нар шилдэг 10-т шалгарч, багаараа 32 байгууллагаас 6-р байр эзэлсэн амжилт гаргалаа.



Олон улсын тэмцээн

04 сарын 01-нээс 04 сарын 10-ны хооронд Шри-Ланка улсад зохион байгуулагдсан өсвөрийн шатарчдын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээний Рапид төрөл, 8 насны охидын ангилалд М.Маргад шагналт 5-р байр эзэлж, багаараа мөнгөн медаль хүртсэн амжилт үзүүллээ.



Тайланд улсын Бангкок хотноо зохион байгуулагдсан Зүүн азийн 4 дэх удаагийн өсвөрийн шатарчдын аварга шалгаруулах тэмцээнд ГОВЬСҮМБЭР аймгийн СҮМБЭР сумын 5-р сургуулийн 3-р ангийн сурагч Мөнхпүрэвийн МАРГАД амжилттай оролцож 3 алт, 1 мөнгөн медаль хүртсэн бахдам амжилтыг үзүүллээ. Тэрээр 8 хүртэлх насны охидын ангилалын Стандарт төрөлд АЛТ, Рапид төрөлд АЛТ, Блиц төрөлд ганцаарчилсан дүнгээр МӨНГӨ, багийн дүнгээр АЛТАН медаль хүртлээ. Мөн дээрх амжилтаараа “ОЛОН УЛСЫН ШАТРЫН ХОЛБООНЫ ДЭД МАСТЕР” цолны болзол биелүүллээ.



Монголын Хүүхдийн спортын VI их наадмын шигшээ тэмцээнд Говьсүмбэр аймгийн баг тамирчид спортын 17 төрөлд 133 тамирчин, 17 дасгалжуулагч нийт 150 хүний бүрэлдэхүүнтэй оролцож 2 алт, 1 мөнгө, 6 хүрэл медаль хүртлээ.

Хүүхдийн спортын VI наадмын нээлтийн үйл ажиллагаа Буянт ухаа спорт ордонд IX/10-ны өдөр ёслол төгөлдөр боллоо.

Тус арга хэмжээнд Монгол улсын ерөнхий сайд У.Хүрэлсүх, БСШУСЯамны дэд сайд Н.Ганбаяр, БСШУСЯамны БТС-ын БЗГ-ын дарга Э.Мөнхбилэг, ЗГХА-БТСГ-ын дарга Ц.Шаравжамц тэргүүтэй албаны хүмүүс болон 21 аймаг 9 дүүргийн 6500 гаруй тамирчин хүүхдүүдэд оролцсон. Нээлтийн ёслолд Говьсүмбэр аймгийн засаг дарга Г.Батсуурь хүрэлцэн ирж баг тамирчдад баяр хүргэж амжилт хүссэн.

Үндсэн төрөлд:

· Ширээний теннисний төрлийн охидын ганцаарчилсан төрөлд Говьсүмбэр аймгийн 5 дугаар сургуулийн сурагч, Ширээний Теннис Сансар Хайрхан клубын тамирчин Г.Сэлэнгэмөрөн хүрэл медаль хүртлээ. Хөвгүүдийн ганцаарчилсан төрөлд 5 суруулийн сурагч, Сансар хайрхан клубын тамирчин Д.Нямбаяр алтан медаль, хосын төрөлд Г.Сэлэнгэмөрөн, Д.Нямбаяр нар мөнгө медаль, багийн нэгдсэн дүнгээр 2-р байр эзэлсэн амжилт үзүүлсэн.

· Боксын төрөлд Говьсүмбэр аймгийн ОУХМ Л.Зоригтбаатар дасгалжуулагчтай Шивээ-овоо хк-ны дэргэдэх Хаялга спорт клубын тамирчин Б.Отгонбаяр 60кг жинд хүрэл медаль хүртлээ. хөнгөн атлетикийн 100 метрийн төрөлд 5-р сургуулийн сурагч Б.Г эрэлт-Од 11,15 долийн амжилтаар спортын дэд мастерийн болзол хангаж 3-р байр байр хүрэл медаль хүртсэн. Мөн 200 метрийн төрөлд 23,74 долийн амжилтаар 4-р байр эзэлсэн.

· Волейболын эрэгтэй баг тамирчид 16 багаас 4-р байранд орсон амжилт үзүүлсэн.

Сагсан бамбөгийн 3*3 баг тамирчид 30 багаас 4-р байранд орсон.

Шатрын төрөлд 5-р сургуулийн тамирчин М.Маргад 5-р байранд орсон.

Сонгох төрөлд:

Крикетын төрөлд Говьсүмбэр аймгийн эмэгтэй баг тамирчид хүрэл медаль хүртлээ. Эрэгтэй баг тамирчид 4-р байранд шалгарсан.

Паралимпийн төрөлд:

паражүдо хөнгөн атлетикийн 800м гүйлтэнд Говьсүмбэр аймгийн Д.Батбаатар алтан медаль, бочигийн төрөлд Н.Ундрам хүрэл медаль хүртлээ.паражүдо бөхийн төрөлд Говьсүмбэр аймгийн тамирчин Х.Энхзориг -55кг жинд хүрэл медаль хүртлээ.



